



International Behavior
Analysis Organization
Elites, Education, Enigmas

ОУЗТСБ-ын ёс зүйн удирдамж

ОУ-н зан төлөв
судлалын
байгууллага
2021 v100


Орчуулсан
Намжилын Солонго

2020 оны 2-р сард Олон улсын зан төлөв судлалын байгууллагын Мэргэжлийн зөвлөлийг хэд хэдэн тусдаа хороо болгон зохион байгуулж 2021 онд ОУЗТСудлаачид болон ОУЗТЭмч нарыг гэрчилгээжүүлэхэд тавигдах шаардлагуудыг тодорхойлох ажлыг үүрэг болгосон. Эдгээр хороодын нэг нь Ёс зүйн хороо бөгөөд уг хороо дэлхийн өнцөг булан бүрт бий болсон янз бүрийн мэргэжлийн ёс зүйн удирдамж, заавар, дүрмийг судлах, хэлэлцэх, мэтгэлцэх, мөн харьцуулан тайлбарлах чиглэлээр ихээхэн амжилттай ажиллав.

Энэхүү нөр их хөдөлмөр, мэдлэг, мэдээллийг ашиглан дэлхийн улс орнуудын өөр өөр соёлд үнэ цэнэ бүхий ёс зүйн шаардлагуудыг нэгтгэн боловсрууллаа. Чухал үүрэг гүйцэтгэсэн тус хорооны гишүүдийн хичээл зүтгэл, мэргэжлийн ур чадвар, няхуур нямбай ажиллагааг бид бүхэн өндрөөр үнэлэх ёстой.

ОУЗТСБ-ын ёс зүйн хорооны гишүүд

- Жэссика Кэлли, ШУ-ны магистр, Зан төлөв судлаач, ОУЗТСБ – Швейцарь
- Стэф Шульдт, Сэтгэл судлаач, Зан төлөв судлаач (BCBA), ОУЗТСБ – ХБНГУ
- Хира Хан, Боловсрол судлалын магистр, Зан төлөв судлаач ажилтан (RBT), ОУЗТСБ – Египт/Пакистан
- Фан Ю Лин, Др (Ph.D), Зан төлөв судлаач (BCBA-D), ОУЗТСБ – БНХАУ
- Жуллиан Бэлл, ШУ-ны магистр – ИБУИВУ, Зан төлөв судлаач (BCBA), ОУЗТСБ
- Александриа Виганд, ШУ-ны магистр, Бизнесийн удирдлагын магистр, Зан төлөв судлаач (BCBA), ОУЗТСБ – Бахрейн
- Аканкша Четтри, М.А, Зан төлөв судлаач (BCBA), ОУЗТСБ – Гуана
- Мариа Штосик, М.А, хэл ярианы эмгэг судлаач (SLP) – Серби
- Рэйчел Арнолд, Боловсрол судлалын магистр – Өмнөд Солонгос
- Вироника Сирбу, М.А – Бүгд Найрамдах Молдав Улс
- Росс Лэйнер, М.А, ОУЗТСБ – Австрали
- Хэнриттэ Брандтбэрг, Сэтгэл судлаач M.Sc, ОУЗТСБ – Дани
- Мохаммед М. Ал-Хаммури, Ph.D, ОУЗТСБ, Эрүүл мэнд, бие бялдрын цогц боловсрол (CHPE), RN – Йордан
- Орсоля Ужхэли-Иллэс, MS, Зан төлөв судлаач (BCBA), ОУЗТСБ – Унгар
- Майкл М.Мюллер, Ph.D., Зан төлөв судлаач (BCBA-D), ОУЗТСБ –
- АНУ



Олон улсын зан төлөв судлалын байгууллагын ёс зүйн удирдамж нь Удирдамж, Ёс зүйн асуудал шийдвэрлэх загвар, тус загварыг ашигласан өөр соёл, бүс нутгийн жишээнүүд, мөн удирдамжийн орчуулга, тайлбар гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Ёс зүй гэдэг нь хатуу тодорхойлсон ойлголт биш бөгөөд нөхцөл байдал бүрд яг ижил байдлаар үйлчилдэггүй. Зан төлөв судлаач мэргэжилтэн (IBA), ажилтан (IBT) бүр энэхүү удирдамжийг ажил, мэргэжлийнхээ хүрээнд ойлгож, алхам тутамдаа хэрэгжүүлэх үүрэгтэй.



Ёс зүйн
удирдамж



Ёс зүйн
асуудал
шийдвэрлэх
загвар



Жишээ
хавсралт


Өмнөх үг

Олон улсын зан төлвийн судалгааны байгууллага (ОУЗТСБ/IBAO) нь Олон улсын зан төлөв судлаачид (ОУЗТС/IBAs) болон Олон улсын зан үйлийн эмч нарын (ОУЗТЭ/IBTs) мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дараах ёс зүйн зарчмуудыг боловсруулав. ОУЗТСБ-аас итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд эмзэг бүлгийн хүмүүсийг хамгаалж, Хэрэглэгчийн зан төлвийн шинжилгээний (ХЗТШ/ABA) салбарыг ямагт хүмүүнлэг байлгахын тулд өөрсдийн үйл ажиллагаа, мэргэжлийн харилцаа, олон нийттэй харилцахдаа ёс зүйн дээд хэм хэмжээг баримтлах ёстой. ОУЗТСБ-аар итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд өөрсдийн бүхий л үйл ажиллагаандаа дараах ёс зүйн удирдамжийг дагаж мөрдөх шаардлагатай.

Ёс суртахууны удирдамжийг хэвлэн нийтэлснээр ОУЗТСБ-аар итгэмжлэгдсэн бүх мэргэжилтнүүд удирдамжийг заавал дагаж мөрдөх эрх зүйн үндэс үүснэ. ОУЗТС болон ОУЗТЭ бүр гэрчилгээжүүлэлтийн сургалт, дадлага эхэлсэн хойш, итгэмжлэлийн хүчинтэй хугацаанд дараах зарчмуудыг дагаж мөрдөхийг зөвшөөрсөнд тооцно.

ОУЗТСБ-ын ёс зүйн удирдамж нь бүх төрлийн нөхцөл байдалд ашиглагдана. Эдгээр удирдамж нь нэн түрүүнд хэрэглэгчдийг, түүнчлэн ХЗТШ, ОУЗТС/ОУЗТЭ (IBA/IBT) болон бусад бүх боломжит талуудыг хамгаалахад чиглэнэ. ОУЗТСБ нь Розенберг, Шварц (2018) нарын бүтээлд үндэслэсэн ёс зүйн асуудлыг шийдвэрлэх загварыг боловсруулсан болно. Бүхий л нөхцөл байдалд ёс суртахууны дүрмийг зайлшгүй дагаж мөрдөх хатуу үзэл баримтлалд баригдахын оронд ОУЗТС/ОУЗТЭ нар зарим удирдамжууд бодит нөхцөл байдалтай зөрчилдөх тохиолдолд нийтлэг ухамсрын загварыг (хувийн болон ёс суртахууны өндөр стандарт баримталж) ашиглах ёстой. Гэхдээ энэ нь удирдамжийг цогцоор нь цаг ямагт дагаж мөрдөх үүргээс чөлөөлөхгүй. Харин тухайн нөхцөл байдалдаа тохируулан хэрхэн хэрэгжүүлэх арга хэлбэр нь өөр байж болно. Удирдамжийн сүүлийн хэсэгт Ёс зүйн асуудлыг шийдвэрлэх загвар болон түүнийг хэрхэн ашиглаж, хэрэгжүүлэх тухай жишээ бий. ОУЗТСБ нь бүх оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн шийдлийг олоход туслах зорилгоор холбогдох ёс зүйн мэргэжилтэн, зөвлөхүүдээс бүрдсэн Ёс зүйн хороог үргэлжлүүлэн ажиллуулах болно.

Н.Э.Розенберг, И.С. Шварц. Удирдамж чиглэл ба хэрэгжүүлэлт: Хэрхэн ёс зүйтэй зан үйлийн шинжээч болох вэ?. Зан үйлийн шинжилгээ 12, 473–482 (2018).



1. Үйлчлүүлэгчийн эрх, нэр хүндийг хамгаалах тухай

1.1. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчиддээ хүндэтгэлтэй хандаж, тэдний нэр төрийг үргэлж хамгаалах ёстой. Боломжтой бол үйлчлүүлэгчдийн санал хүсэлт, сонголтыг ямагт харгалзаж үзнэ. Бүх үйлчилгээг энэрэнгүй, чин сэтгэлээсээ үзүүлэх ёстой.

1.2. Хор хөнөөл учруулахгүй байх/Үйлчлүүлэгчийг хамгаалах. Үйлчлүүлэгчдийг ямар нэг байдлаар хохироохгүйн тулд бүхий л харилцаа холбоо, үйлчилгээг болгоомжтой үзүүлнэ. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд нь үйлчлүүлэгч болон тэдний орчин нөхцөлд эерэг өөрчлөлт авчирч, нэн түрүүнд тэдний сэтгэл зүйн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор үйлчилнэ.

1.3. Эмчилгээ үйлчилгээ үзүүлэхдээ хамгийн өндөр үр дүнтэй бөгөөд хамгийн бага нөлөөтэй аргыг сонгоно.

1.4. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой гарч болох эрсдэл, ашиг тусын тухай танилцуулж, үйлчилгээ, зан төлвийн үнэлгээ, ажиглалт, оролцоо, нууц мэдээлэл солилцох тухай, үйлчилгээ үзүүлэх явцад гарах өөрчлөлтүүд, аудио болон видео бичлэг хийх, мэдээлэл солилцох талаар бичгээр зөвшөөрөл авах ёстой.

1.5. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчтэй холбоотой бүхий л төрлийн хувийн мэдээллийг хүндэтгэж, нууцлалыг хамгаална. Үйлчлүүлэгч хүчирхийлэл/хайхрамжгүй байдлын хохирогч болох, эмнэлгийн байгууллагын хэрэгцээ (жишээ нь, эмнэлгийн яаралтай тусламжийн үед оношийг мэдээлэх) шаардлага үүсэх, үйлчлүүлэгчид ноцтой аюул тулгарсан, эсвэл хуулийн шаардлага бий болсон тохиолдолд нууцлалыг задруулах боломжтой. Хууль хүчний байгууллагаас үйлчлүүлэгчийн мэдээллийг шаардсан тохиолдолд зөвхөн холбогдох мэдээллийг гаргаж болно.

1.6. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд аливаа бүртгэл, хувийн мэдээлэлтэй холбоотой баримт бичгүүдийг хамгийн багадаа 7 жил ба тухайн орон нутгийн дүрэм журмын дагуу түүнээс урт хугацаанд аюулгүй, найдвартай хадгална. Эдгээр баримт бичгийн төрөлд сорил, үнэлгээнүүд, үйлчлүүлэгчтэй харилцсан болон ажиглалтын тэмдэглэл, уулзалт ярилцлагын дараах дүгнэлт, асран хамгаалагчтай хийсэн ярилцлагын тэмдэглэл, мөн түүнчлэн аливаа байгууллага, санхүү болон гэрээ хэлэлцээрийн баримт бичгүүд багтаж болно. Үйлчлүүлэгчид өөрсөдтэй нь холбоотой баримт бичигтэй танилцах эрхтэй бөгөөд тэдгээрийг аль нэг гуравдагч этгээдтэй (жишээлбэл, аль нэг төрийн албан хаагч) хуваалцахын өмнө заавал зөвшөөрөл авах шаардлагатай.

2. Ялгаатай байдлыг хүндэтгэх

2.1 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд хүний эрх, ижил тэгш байдлыг эрхэмлэн, үйлчилгээ үзүүлэхдээ хэн нэгнийг хөгжлийн бэрхшээлтэй байдал, арьс өнгө, үндэс угсаа, хүйс, бэлгийн чиг хандлага, шашны итгэл үнэмшил, нас болон нийгэм-эдийн засгийн байдлаар нь ялгаварлан гадуурхах ёсгүй. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчидтэйгээ ижил тэгш хандаж, үйлчлүүлэгч нэг бүрийг тусдаа бие хүн гэж үзэн тухайн хувь хүний онцлог хэрэгцээ шаардлагыг хангахын тулд ажиллана.

2.2 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд өөрсдийнхөөс өөр соёлын зан үйлийг хүндэтгэнэ. Өөрийн гэсэн итгэл үнэмшил, үнэт зүйл, соёлын хэм хэмжээ бүхий хэрэглэгчид болон бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахдаа тэдгээр ялгааг харилцан ойлголцох, хүлээцтэй, мөн хүндэтгэлтэй хандахын тулд шаардлагатай хүчин чармайлт гаргаж ажиллана. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд өөрийн хувийн хэвшмэл үзлийн нөлөөлөлгүй, субъектив биш үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

2.3 Үйлчлүүлэгч болон итгэмжлэгдсэн мэргэжилтнүүдийн хоорондын ялгаанаас үл хамааран итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд асуудал, нөхцөл байдалд үргэлж бодитоор хандаж, мэргэжлийн үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлэх ёстой. Хэрэв ямар нэг шалтгааны улмаас мэргэжилтний хандлага, дүгнэлтэд зүй бус нөлөө гарч байна гэж үзвэл итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үйлчилгээ үзүүлэх эсэх шийдвэрээ эргэж харах хэрэгтэй.

3. Ур чадвар ба туршлага

3.1 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд бүхий л үйлчилгээ, мэргэжлийн харилцаа холбоо, бизнес болон арилжааны үйл ажиллагаандаа үнэнч шударга байдал болон чанарыг эрхэмлэнэ.

3.2 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үйлчлүүлэгч нарт мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн нэгдмэл байдлыг хангахын тулд салбар дунд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны үр дүн, мэдээллийн сан болон зан төлвийн холбогдолтой батлагдсан онолуудад тулгуурлана.

3.3 Аюулгүй байдал нэн тэргүүнд байх ёстой. Аливаа үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг эрсдэлд оруулж болохгүй. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал эрсдэлд орсон тохиолдолд итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд ажил үйлчилгээгээ шууд зогсоож, дахин үргэлжлүүлэхийн өмнө аюултай нөхцөл байдлыг залруулахын тулд шаардлагатай бүх арга хэмжээг авна. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд зан төлвийн холбогдолтой үйл ажиллагаанд баримтлах хязгаарыг мэддэг, баримталдаг байх ёстой.

3.4 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд ур чадвар/мэргэшлийн хүрээндээ хамаарах ажил үйлчилгээ явуулна. Тэд өөрсдийн боловсрол, мэргэжлийн бэлтгэл, туршлагадаа үндэслэн бие даасан үйлчилгээ үзүүлдэг. Өөрийн бэлтгэгдсэн сургалт, дадлагаас гадуурх чиглэлээр ажил үйлчилгээ үзүүлэхийн тулд холбогдох нэмэлт сургалтад хамрагдаж, хяналт, удирдлагын дор ажиллах шаардлагатай.

3. Ур чадвар ба туршлага

3.5 Ур чадвараа сайжруулах/төгөлдөрших. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд зан төлвийн шинжилгээ, үйлчилгээний ёс зүйн талаарх мэдлэгээ тасралтгүй сайжруулах ёстой. Мэргэжилтнүүд Тогтмол хөгжил, боловсрол (ТХБ/СЕ)-ын арга хэмжээнүүдээр дамжуулан суралцах боломжтой. Мөн зайлшгүй хамрагдах шаардлагатай тэдгээр ТХБ арга хэмжээнүүдээс гадна салбарын хөгжил, орчин үеийн ёс зүйн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхахын тулд бусад төрлийн сурч боловсрох арга, хэрэгслүүдийг бүрэн ашиглаж өөрсдийгөө цаг ямагт хөгжүүлэхийг эрмэлзэх шаардлагатай.

3.6 Шинжлэх ухаанд үндэслэсэн ажил, үйлчилгээ. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд зан төлвийн сорил, үнэлгээ, хэвшмэл зан төлвийг өөрчлөх ажиллагаа болон бусад бүх төрлийн үйл ажиллагаандаа үнэн бодит өгөгдөлд суурилсан шийдвэр гаргаж ажиллана. Бүхий л үнэлгээ, нөлөөллийн арга ажиллагаа нь зан төлвийн шинжилгээний онол эсвэл хэвлэгдэж, нийтлэгдсэн ном зохиолд үндэслэсэн байх ёстой. Мэргэжилтнүүд судалгаа болон ажил үйлчилгээндээ дан ганц кэйсд суурилсан туршилтын загварыг ашиглах бөгөөд ингэснээр хуримтлагдсан нийт өгөгдөл дундаас тодорхой хэмжигдэхүүнүүдийн дагуу дүн шинжилгээ хийж шийдвэр гаргалтад ашиглах боломжтой болно.

4. Менежмент, удирдлага ба сургалт

4.1 Итгэмжлэгдсэн болон итгэмжлэлгүй ажил олгогчийн харъяанд бусдыг удирдан чиглүүлэх үүрэг гүйцэтгэж буй мэргэжилтнүүд дагалдан суралцагсдаа хүндэтгэж, анхаарч, халамжлахын зэрэгцээ шударга ёсыг эрхэмлэн ажиллах ёстой. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд дагалдан суралцагчдаа мэдлэгтэй, чадвартай, ёс зүйтэй мэргэжилтэн болж бэлтгэгдэхэд тусалснаараа ХЗТШ-ий салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж буй хэрэг юм

4.2 ХЗТШ-ий салбарыг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэхийн тулд итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд хямд өртөг бүхий менторшип хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжлийн туслалцаа үзүүлж ажиллах нь зүйтэй. Шинээр ажиллаж эхэлж буй мэргэжилтнүүдийн хувьд ажил, үйлчилгээний өртгийг бүс нутаг, орлогын дундаж түвшин зэргийг харгалзан тогтооно.

4.3 Суралцаж дадлагажиж буй мэргэжилтнүүд ОУЗТСБ-ын стандартад заасан цагаар сургалт, дадлагад хамрагдсан байх ёстой.

4.4 Сургалт, дадлага удирдан явуулж буй мэргэжилтэн энэ тухайгаа үйлчлүүлэгч болон бусад оролцогч талуудад мэдэгдэнэ.

4.5 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд удирдан явуулж буй дадлагын үйл ажиллагааг зохих журмын дагуу баримтжуулж, дадлагажигч үүрэг даалгавраа хангалттай хэмжээнд гүйцэтгэсний дараа гарын үсэг зуран баталгаажуулна.

4.6 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд зөвхөн өөрсдийн мэдлэг, ур чадвар, туршлагын хүрээнд бусдын сургалт, дадлагыг удирдан явуулах боломжтой. Өөрийн дадлагажигч мэргэжилтэн нь ёс зүйгүй хандлага, үйлдэл гаргаж байгааг итгэмжлэгдсэн мэргэжилтэн олж мэдсэн даруй гадаад, дотоод оюутан байхаас үл хамааран тухайн оюутанд ил тод, тодорхой мэдэгдэх үүрэгтэй. Тухайн асуудалд шийдэл олох юмуу, аль эсвэл хамтын ажиллагааг зогсоож болно. Сургалт, дадлагын үйл ажиллагаа нь дадлагажигч мэргэжилтний зорилго, горилж

4.7 Өөрийн дадлагажигч мэргэжилтэн нь ёс зүйгүй хандлага, үйлдэл гаргаж байгааг итгэмжлэгдсэн мэргэжилтэн олж мэдсэн даруй гадаад, дотоод оюутан байхаас үл хамааран тухайн оюутанд ил тод, тодорхой мэдэгдэх үүрэгтэй. Тухайн асуудалд шийдэл олох юмуу, аль эсвэл хамтын ажиллагааг зогсоож болно. Сургалт, дадлагын үйл ажиллагаа нь дадлагажигч мэргэжилтний зорилго, горилж буй гэрчилгээний шаардлагыг хангаж буй эсэх дээр итгэмжлэгдсэн мэргэжилтэн хариуцаж, үүрэг хүлээнэ.

5. Нийгмийн хариуцлага

5.1 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд аливаа зарлал, сурталчилгаанд зөвхөн үнэн зөв мэдээлэл ашиглах бөгөөд ажил, үйлчилгээний дараа гарах боломжит үр дүнг бодитоор тодорхойлно.

5.2 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчдээс ирсэн юмуу олон нийтэд нээлттэй үнэлгээг өөрсдийн сурталчилгаанд ашиглахдаа тэдгээрийг ямар нэг байдлаар өөрчлөхгүй бөгөөд хүлээн авч цуглуулсан нийт үнэлгээний үр дүнг хамтад нь танилцуулна.

5.3 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд олонд нийтлэгдсэн мэдээлэл, санал, үнэлгээг өөрсдийн сурталчилгаанд ашиглахдаа ажил, үйлчилгээний үндсэн зорилго алдагдаагүй байхад анхаарна.

5.4 Хэрэв насанд хүрээгүй хүмүүсийн зураг, бичлэгийг сурталчилгаанд ашиглах бол тухайн зураг, бичлэгийг тийнхүү интернэт сүлжээнд нийтлэх нь зураг, бичлэг дээр гарч буй этгээдийн эрх болоод сэтгэл зүйн байдалд одоо болон ирээдүйд нөлөөлөхгүй байхаар бодолцох шаардлагатай.

5.5 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд өөрсдийн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээг үнэн зөв танилцуулж, бүгдэд нээлттэй, ил тод харуулахын зэрэгцээ мэргэжлийн ёс зүйг эрхэмлэж ажиллана.

5.6 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд ёс зүйг баримталж салбартаа ёс зүйт соёлыг түгээн дэлгэрүүлэх үүрэгтэй бөгөөд бусдад үлгэр жишээ байх ёстой.

5.7 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд нь нийгмийн сүлжээнд нийтлэх аливаа мэдээ, баримт үйлчлүүлэгчийн хувийн нууц, нууц хадгалах эрх зэрэг ёс зүйн удирдамжийг зөрчихгүй байх нөхцлийг хангаж ажиллана.

5.8 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчид өөрсдийн санал хүсэлт, дуу хоолойгоо хүргэхэд тохиромжтой сувагуудын талаар мэдээлэл өгнө.

5.9 Үйлчлүүлэгч шүүмж, санал сэтгэгдэл илэрхийлсэн тохиолдолд итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үүнийг мэргэжлийн ёс зүйтэйгээр хүлээн авч, үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд нийцүүлэн нөхцөл байдлыг залруулж ажиллана.

5.10 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд ОУЗТСБ болон бусад байгууллагын оюуны өмчийг зөвхөн албан ёсны зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэйгээр, орон нутгийн хууль тогтоомжийн дагуу ашиглана. ОУЗТСБ-ын оюуны өмчийн ашиглалтын талаархи асуудлыг info@theibao.com хаягаар илгээнэ үү.

6. Мэргэжлийн харилцаа

6.1 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үйлчилгээ үзүүлж эхлэхийн өмнө "үйлчлүүлэгч"-ийг таньж, тодорхойлж, холбогдогч бүх талуудад танилцуулна. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд "үйлчлүүлэгч"-ийг үйлчилгээний төлбөр төлж буй төдий хүн биш харин үйлчилгээний эцсийн хүлээн авагч гэж үзнэ..

6.2 Байгууллагууд ОУЗТС-аар үйлчлүүлж болно. Байгууллагууд ажилтнуудын сургалт, оффисын бүтээмж нэмэгдүүлэх хөтөлбөрүүд, зан төлвийн хөгжилд зориулсан сургалт зэрэг ба эдгээрээс бусад төрлийн үйлчилгээ авч болно.

6.3 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчдийнхээ туйлын ашиг сонирхлын төлөө ажиллана. Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд мөлжлөгийн шинж чанартай мэргэжлийн харилцаанд оролцохгүй.

6.4 Зарим хоёр талт харилцаа бэрхшээлтэй, тулгарсан асуудлыг бодитоор авч үзэж шийдвэрлэхэд хүндрэлтэй байж болохыг итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд мэдэж байх ёстой. Энэ тохиолдолд итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд бүх оролцогч талуудад үүсээд буй ашиг сонирхлын зөрчил, тэдгээрийн бий болгож болзошгүй нөлөөллийн талаар мэдээлнэ. Хэрэв асуудалд бодитоор хандах байдал алдагдсан бол тухайн харилцааг эргэн харах шаардлагатай.

6.5 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд ажил олгогч, бизнес эрхэлж буй газар болон үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой гэрээний үүрэг, хуулиар хүлээсэн үүрэг, мөн аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн үүргийг эрхэмлэн хүндэтгэнэ.

6.6 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд нэн түрүүнд үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг эрхэмлэн бусад салбар, эмчилгээний байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

6.7 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчид болон бусад талуудтай гэрээний харилцаанд орох үед гэрээ, санхүүгийн зохицуулалт болон бусад холбогдох санхүүгийн асуудлуудтай холбоотой зардлыг үйлчилгээ үзүүлж эхлэхээс өмнө тохиролцсон байх ёстой.

6.8 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд боломжтой бол хувь хүн, байгууллагын буруутай үйл ажиллагаа, зүй бус үйлдлийн эсрэг арга хэмжээ авна. Эсэргүүцлийн арга хэмжээг амаар, бичгээр эсвэл холбогдогч байгууллагуудад мэдэгдэх хэлбэрээр байж болно. Ингэснээр итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд ХЗТШ-ий салбарын ёс зүйг хамгаалж, олон нийт дундах нэр хүндийг өндөрт өргөхөд хувь нэмрээ оруулах юм.

6.9 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд мэргэжлийн хил хязгаарыг янз бүрийн аргаар хадгална.

- a) Хэрэв үйлчлүүлэгч нь мэргэжилтний үйлчилгээг шууд хүлээн авч буй хувь хүн бол үйлчилгээ зогссоноос хойш дор хаяж хоёр жилийн хугацаанд тухайн хүнтэй платоник (бэлгийн болон хайр дурлалын бус дотно харилцаа) харилцаатай байна.
- b) Үйлчлүүлэгчтэй тогтоосон мэргэжлийн харилцаа бүрэн дуусах хүртэл үйлчлүүлэгчийн асран хамгаалагчид болон бусад сонирхогч талуудтай мөн адил платоник (бэлгийн болон хайр дурлалын бус дотно харилцаа) харилцаатай байна.
- c) Хэрэв үйлчлүүлэгч нь байгууллага бол мэргэжлийн харилцааг бүрэн дуусгах хүртэл тухайн байгууллагын хүмүүстэй платоник (бэлгийн болон хайр дурлалын бус дотно харилцаа) харилцаатай байна.

7. Итгэмжлэгдсэн мэргэжилтэн хувь хүний хариуцлага

7.1 Эдгээр удирдамжийг харгалзан үзвэл итгэмжлэгдсэн мэргэжилтний хувийн ашиг сонирхол нь олон нийт, үйлчлүүлэгч, бүх холбогдогч оролцогч талууд болон ХЗТШ-ий салбарын ашиг сонирхлын дараа тавигдана. Аливаа шийдвэр гаргахдаа энэхүү дарааллыг харгалзах ёстой.

7.2 Аливаа үйлчилгээ үзүүлэх эсвэл мэргэжлийн харилцаагаа үргэлжлүүлэхэд асуудал, нөхцөл байдалд бодитоор хандах боломжгүй болсон тохиолдолд үүнийг хүлээн зөвшөөрч, үйлчлүүлэгч болон бүх оролцогч талуудын нэр төрийг хамгаалах, түүнчлэн салбар, мэргэжлийн ёс зүйг хамгаалах шийдлийг олох нь итгэмжлэгдсэн мэргэжилтний үүрэг юм.

7.3 Цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон нөхцөлд өөр мэргэжилтэн рүү түр эсвэл бүрмөсөн шилжүүлэх, өөр мэргэжилтэн, байгууллага санал болгох, тулгарч буй тодорхой асуудалд илүү туршлагатай зан төлөв шинжээчидтэй зөвлөлдөх, эсвэл бэрхшээлтэй асуудлаар мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа авах зэргээр шийдвэрлэнэ.

8. Судалгаа, нийтлэл

8.1 Судалгаа явуулахын өмнө бүх оролцогчдод мэдээлэл өгч, бичгээр зөвшөөрөл авна. Судалгаанд оролцогчдын нууцыг чандлан хадгалах ёстой.

8.2 Судалгаанд оролцогчдод хэрхэн яаж оролцох тухай, оролцоо нь ямар ач холбогдолтой талаар, мөн ямар ч үед, ямар ч шалтгаанаар оролцохоос татгалзаж болох тухай тайлбарлаж өгөх ёстой.

8.3 Судалгааны үр дүнг тайлбарлаж, хууран мэхлэх шинж чанартай аливаа үйлдэл илэрсэн тохиолдолд судалгааны дараах товч танилцуулга хийх ёстой.

8.4 Аливаа судалгааны төсөлд оролцогчдыг сонгон шалгаруулж эхлэхээс өмнө холбогдох байгууллага юмуу орон нутгийн дотоод хяналтын хорооноос зөвшөөрөл авна.

8.5 Бүтээлийн нийтлэл дээр хувь нэмэр оруулж оролцсон зохиогчдыг үнэн зөв тусгасан байх ёстой.

8.6 Судалгааны үр дүнг танилцуулахдаа бүхий л тохиолдолд мэдээ, баримтыг үнэн бодитоор илэрхийлнэ.

8.7 Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд зөвхөн өөрсдийн бүтээлийг эзэмшиж, төлөөлөх эрхтэй. Бусдын бүтээлээс зохих ёсоор иш татах тохиолдолд ХЗТШ-д мөрдөгдөж буй салбарын стандартыг дагаж мөрдөхийн сацуу, судалгаа явуулж, хэрэгжүүлж буй буй улс орны сэтгэл судлалын нийгэмлэгээс баримталдаг хэвлэн нийтлэх удирдамжийн хүчин төгөлдөр хувилбарыг баримтлах ёстой.

Асуудал шийдвэрлэх загвар ашиглан ёс зүйн асуудлыг шийдвэрлэх нь

Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд ХЗТШ-ий салбарт мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцад ёс зүйн зөрчилдөөний улмаас хэрхэн шийдвэрлэхээ мэдэхгүй нөхцөл байдалтай тулгарч болзошгүй. Энэ мэт тохиолдолд мэргэжилтнүүд Розенберг, Щварц нарын тайлбарласан (2018) Ёс зүйн асуудал шийдвэрлэх загварыг ашиглана. Энэхүү загвар нь уг зөрчилдөөн ба түүний эргэн тойрон дахь асуудлуудыг тодорхойлж, боломжит шийдлүүдийг гаргах, тэдгээрийг үнэлж цэгнэх, мөн сонгосон шийдлийг хэрэгжүүлэх зэрэг хэсгүүдээс бүрдэнэ.

Итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд ёс зүйн зөрчилдөөнтэй нөхцөлд орвол дараах арга хэмжээг авна. Үүнд:

- 1) Зөрчилдөөнтэй нөхцөл байдлыг тогтоож, таньж мэдэн ёс зүйн удирдамжийн аль хэсэг зөрчигдөж байгааг ойлгож ав.
- 2) Шаардлагатай бол хамтран ажиллагсад, үйлчлүүлэгч эсвэл асран хамгаалагчтай ярилцаж хэлэлц.
- 3) Боломжит шийдлүүдийг жагсаа.
- 4) Шаардлагатай бол боломжит шийдлүүдийн талаар хамтран ажиллагсад, үйлчлүүлэгч эсвэл асран хамгаалагчидтай ярилцаж, зөвшилцсөний үндсэн дээр шийдвэр гарга.
- 5) Сонгосон шийдлээ хэрэгжүүл.
- 6) Гаргасан шийдвэр болон түүний үр дүнг үнэлж, асуудлыг шийдвэрлэх явцад хамтран ажилласан хүмүүстэй хуваалц.

Асуудал шийдвэрлэх загвар ашиглан ёс зүйн асуудлыг шийдвэрлэх нь

Жишээлбэл, нэгэн ОУЗТС ажил даалгаврын шахалт, шаардлагаас зугтах зорилготой уур, түрэмгийллийн зан үйлийг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж байв. Шаардлагыг биелүүлж, зугтах үйлдэлд саад хийх зорилготой 3 үе шаттай өдөөх ажиллагаа хэрэгжүүлэх үед хүүхэд чангаар уйлж эхэлсэн нь тухайн хүүхэд өмнө нь гаргаж байгаагүй зан үйл байлаа.

ОУЗТС нь зөрчилдөөн байж болзошгүй гэж үзсэн тул тэрээр асуудал шийдвэрлэх загвар ашиглахаар шийдсэн бөгөөд хамгийн эхэнд 1-р алхам болох "Зөрчилдөөн байна гэдгийг таньж мэдэв. Удирдамжийн аль хэсэг зөрчилдөж байгааг тогтоох шаардлагатай."

Тухайн мэргэжилтэн "Хор хөнөөл учруулахгүй байх", мөн ноцтой зан үйлийг удирдахад эдгээр төрлийн дэмжлэгт суурилсан хөндлөнгийн оролцоог дэмждэг "шинжлэх ухаанч практик" ашиглах ёс зүйн удирдамжуудын хооронд зөрчилдсөн гэж үзсэн. Эдгээр ёс зүйн удирдамж хоёулаа зөв, шударга боловч энэ нөхцөлд байдлын хувьд ямар нэг байдлаар зөрчилдөж байна.

"Шаардлагатай бол хамтран ажиллагсад, үйлчлүүлэгч эсвэл асран хамгаалагчтай харилцан яриа өрнүүлэх" тухай 2-р алхамын хүрээнд ОУЗТС нь мэргэжил нэгтнүүдтэй зөвлөлдөж, нөхцөл байдал болон гарч болзошгүй зөрчилдөөний талаарх өөрийн бодлыг тайлбарлав. Ийнхүү зөвлөлдсөний үр дүнд тэрээр "Боломжит шийдлүүдийг жагсаах" 3-р алхам руу шилжив.

Тэрээр эмчилгээг зогсоож, өөр аргачлал сонгох, эмчилгээгээ бүрмөсөн зогсоож, суралцагчид шаардлагаас зайлсхийх боломж олгох, эсвэл анхны эмчилгээгээ үргэлжлүүлэх зэрэг боломжит шийдлүүдийн жагсаалт гаргав.

4-р алхам буюу "Боломжит шийдлийн талаар хамтран ажиллагсад, үйлчлүүлэгч эсвэл асран хамгаалагчтай ярилцаж, үнэлж, шийдэлд хүрэх" үе шатанд тэрээр боломжит шийдлүүдийг нэг нэгээр нь хянаж үзэв. Шинэ аргачлал туршиж үзэх эхний хувилбарын хувьд тэрээр шинэ аргачлал ашиглахын тулд төлөвлөж боловсруулах, зөвшөөрөл авах, ажилтнуудыг сургаж бэлтгэхэд шаардагдах хугацааг тооцоолохын зэрэгцээ үр дүн нь өмнөхтэй ижил буюу өөрчлөлтгүй байх эрсдлийг тооцов. Энэ хувилбар нь Ёс зүйн удирдамжтай ямар нэг байдлаар зөрчилдөхгүй бөгөөд шаардлагатай үр дүнг бий болгохгүй зөвхөн цаг алдах магадлалтай гэж үзэв.

Дараа нь эмчилгээг бүрэн мөсөн зогсоох хоёр дахь хувилбарыг авч үзлээ. Хэдийгээр энэ нь үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн хямралыг хамгийн бага байлгах сонголт мөн боловч бусдад үзүүлэх түрэмгийллийг нь бууруулахгүй, мөн мэргэжилтний дагаж мөрдөх ёстой хэдэн ёс зүйн удирдамжийг зөрчихөд хүргэх сонголт гэж бодов.

Эцэст нь тэрээр анх сонгосон эмчилгээгээ үргэлжлүүлэх гэсэн гурав дахь сонголтыг авч үзэв. Түүний мэргэжлийн туршлага ба бусад ОУЗТС-уудтай зөвлөлдсөн мэдээлэл дээр үндэслэн авч үзэхэд иймэрхүү нөхцөлд сөрөг сэтгэл хөдлөл ажиглагдах нь түгээмэл бөгөөд эмчилгээний төлөвлөгөөнд тусгасан байсан эерэг ятгалгын арга техникийг ашиглахад хэсэг хугацааны дараа засардаг үзэгдэл билээ. Мөн тэрээр "Хор хөнөөл учруулахгүй байх" зарчим нь "таагүй, эвгүй нөхцөл байдалд огт оруулахгүй" гэж ойлгох албагүйг ухамсарлав. Тухайн хүүхэд түрэмгий зан авир гаргасаар сурч боловсрох боломжоо алдсаар байвал энэ нь түүнд илүү хор хөнөөлтэй гэж үзэв.

Ёс зүйн зөрчилдөөнийг Асуудал шийдвэрлэх загвараар зохицуулах нь

“Сонгосон арга, шийдлийг хэрэгжүүлэх” 5-р алхамын хувьд ОУЗТС өөрийн анх сонгож төлөвлөсөн аргачлалаа үргэлжлүүлж, тууштай хэрэгжүүлэв.

6-р алхам болох “Өөрийн гаргасан шийдвэр, түүний үр дүнг үнэлж, асуудлыг шийдвэрлэх явцад зөвлөлдсөн талуудтай хуваалцах”-ын тулд аргачлалыг хэрэгжүүлж эхэлснээс хойш хэд хоногийн дараа өөрийн сонгосон шийдвэр зөв байсан эсэхэд үнэлэлт дүгнэлт хийв. Эмчилгээний дараа хүүхдийн түрэмгийлэх зан авир эрс багасч, зөвхөн эхэн хэсэгт уйлж байснаа зогссон бөгөөд үүний үр дүнд шинэ мэдлэг, чадвар эзэмшүүлэх зорилгууд амжилттай хэрэгжиж байв. ОУЗТС өөрийн шийдвэрийг зөв байсныг батлахын зэрэгцээ энгийн Асуудал шийдвэрлэх загварыг ойлгож авч, амжилттай хэрэгжүүлсэндээ баяртай байлаа.